

REACH

Small and Medium Enterprise Access to Credit

REACH САР ТУТМЫН СОНИН

2016 оны 11 сар №7

ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ:

1. “Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих нь” сэдэвт форум зохион байгууллаа
2. Амжилтын Түүх
3. Таны Мэдлэгт Булан
4. Зээлийн Зуучлал
5. Монгол улсад хэрэгжиж буй олон улсын байгууллагуудын төслүүд
6. Зээлийн Боловсрол
7. Салбаруудад болсон онцлох үйл явдлуудаас
8. Бизнес Зөвлөгөө
9. REACH Төслийн 12 Сард Зохион Байгуулах Үйл Ажиллагааны Хөтөлбөр

ХОЛБОО БАРИХ:

REACH Төслийн оффис:

№ 703, МАКС Тауэр,
Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ + (976) 7722-2210

✉ reach@dsmongolia.org

🌐 www.dsmongolia.org

📘 www.facebook.com/REACHProject

Баян-Өлгий Оффис:

№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв
5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг

☎ Утас: 7042-2080

Дорнод Оффис:

№ 11 тоот, Ольхон Худалдааны Төв,
9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг

☎ Утас: 7058-2030

Дундговь Оффис:

№ 205 тоот, Мандал Шилтгээн ХХК-ийн
байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан сум,
Дундговь аймаг

☎ Утас: 7059-2209

Сэлэнгэ Оффис:

№ 1 тоот, Алтан Булаг Төв
Сүхбаатар сум, 2-р баг, Сэлэнгэ аймаг

☎ Утас: 7036-3440

1. “ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСҮҮДИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ НЬ” СЭДЭВТ ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH Төсөл “Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих нь” сэдэвт форумыг 10 сарын 26-нд зохион байгууллаа.



Тус форум нь жижиг, дунд бизнесийн зээлжих чадавхийг сайжруулахад тооцоолтой, тогтвортой, шинэлэг арга замуудыг оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд бий болгох зорилготойгоор зохион байгуулагдлаа. Энэхүү форумд АНУ-ын ОУХА болон Монгол улсын Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Үндэсний Хөгжлийн хороо, Зээлийн Батлан Даалтын Сан, Монгол Банк зэрэг төрийн байгууллагууд болон АНУ-ын ОУХА-тай хамтран ажиллаж буй арилжааны банкууд, олон улсын төсөл, хөтөлбөрүүд, их, дээд сургуулиуд, инкубатор, бизнес хөгжлийн байгууллагууд оролцож илтгэл тавьлаа. Түүнчлэн энэхүү форумд жижиг, дунд бизнесүүд оролцож жижиг, дунд бизнесийн зээлжих чадавхиа хэрхэн хөгжүүлж амжилттай зээлдэгч болох талаар өөрсдийн саналыг хуваалцлаа.

Энэхүү форум жижиг, дунд бизнесүүдийн зээлжих чадавхийг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, жижиг, дунд бизнесүүдийн зээлжих чадавхийг нэмэгдүүлэхэд банк, санхүүгийн байгууллагуудын оролцоо гэсэн үндсэн хоёр сэдвийн хүрээнд төр болон хувийн хэвшлийн оролцоог уялдуулж, зээлийн бүтээгдэхүүнүүдийг онол, практикт хослуулан гаргах замыг бий болгож, жижиг, дунд бизнесийн орчинд зээлжих чадавхийг нэмэгдүүлэх техник туслалцааны шалгарсан аргыг хэлэлцсэн томоохон арга хэмжээ боллоо.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн REACH төсөл тус форумыг төсөл хэрэгжих хугацаанд жил бүр зохион байгуулах бөгөөд энэ жилийн форумын үр дүнд гарсан зээлийн бүтээгдэхүүн, нөхцөл, шаардлагуудыг жижиг, дунд бизнесүүдэд ээлтэй байдлаар хөгжүүлэх, мөн жижиг, дунд бизнесүүдийн зээлжих чадавхийг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлэх зөвлөмжүүдийг арилжааны банкуудад өгөх юм.

АМЖИЛТЫН ТҮҮХ



Цэрэндуламын Цэцэгмаа нь 1999 онд гэр бүлийн хүний хамт өөрийн амьдардаг 3 өрөө байрныхаа 2 өрөөнд гэрийн шарах шүүгээтэй цех байгуулж, гөөхий хийж бизнесийн гараагаа эхэлжээ. Тухайн үед дэлгүүрийн лангуунд талх нарийн боов ховор, гөөхий их зарагддаг байсан бөгөөд 3 өрөө байраа худалдан цехийн тоног төхөөрөмж авч 20 гаруй ажилтантай болтлоо өргөжин тэлж байсан байна.

Ц.Цэцэгмаа Молор – Өгөөжис ХХК-ийн үйл ажиллагааг байгуулагдсан цагаас хойш тасралтгүй явуулж, үйлдвэрлэсэн хэвийн боов, еэвэн нь өөрийн гэсэн брэндийг бий болгож чадсан бөгөөд аймагтаа болдог “Цагаан сар - 2016” үзэсгэлэн худалдаанд шилдэг борлуулалттай компаниар шалгарсан нь үүний нэг жишээ юм.

Цэцэгмаа бараа бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулах зорилгоор эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх банкнаас зээл авах хүсэлтэй байсан хэдий ч зээл авахад шаардагдах бичиг баримтын бүрдүүлэлт, зээлийн тооцоолол хийхэд зөвлөмж, туслалцаа шаардлагатай байв.

Тэрээр АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /ОУХА/-ийн REACH төсөл Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлэл авснаар зээлийн зуучлалын үйлчилгээ авах боломжтой гэдгийг ойлгосон юм.

“REACH төслийн тусламжтайгаар хүссэн санхүүжилтээ авч, “хөрөнгийн талх” бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж эхлээд байна. REACH төсөл хэрэгжиж байгаад баяртай байна”

Ц.Цэцэгмаа АНУ-ын ОУХА-ийн REACH төслийн үр дүнтэй зөвлөмж мэдээллийн дагуу зээлийн бичиг баримтын бүрдүүлэлтээ богино хугацаанд бүрдүүлж чадсанаар авсан зээлээрээ өдөрт 500 ширхэг талх борлуулж, борлуулалтын орлогоо ихээхэн нэмэгдүүлж чадсан юм.

Цаашид Цэцэгмаа цехийн байрыг барих санхүүжилтэд зориулан бизнес төсөл боловсруулан банк санхүүгийн байгууллагаас урт хугацаатай, хүү багатай зээлийн санхүүжилт олж авахаар REACH төсөлтэй хамтран ажиллаж байна.

Бизнесийн салбар:

Талх, нарийн боов

Бизнесийн нэр:

Молор-Өгөөжис ХХК

Байршил:

Дорнод аймаг

Бизнес эрхлэгчийн овог, нэр:

Цэрэндуламын Цэцэгмаа





3. ТАНЫ МЭДЛЭГТ БУЛАН



САНХҮҮ БА САНХҮҮЖИЛТ

Амжилт олох бизнесийн хувьд хамгийн наад захын гурван шаардлага байдаг

1. санхүүгийн үйл ажиллагааны үр дүн сайн байх,
2. баланс дахь авлага, өглөгийн харьцаа зөв байх
3. бэлэн мөнгөний урсгал зөв байх.

Эдгээр нь их нарийн мэргэжлийн нэр томъёонууд мэт сонсогдох боловч энэ бүгд жирийн нэг хялбархан мөнгөн орлого, зарлагын бүртгэлийн дэвтрээс эхэлдэг.

Мөнгө урсгалын сайн бүртгэлээс бүхнийг эхэл

Санхүүгийн бүртгэлээ аль болох энгийн хялбархан хөтөл. Эхлээд мөнгөн орлого зарлагаа маш сайн бүртгэ. Энэ нь өдөрт орсон мөнгө орлого, өдөрт гарсан мөнгөн зарлага, тэдгээрийн баланс. Мөнгөн орлого зарлагын бүртгэл бол санхүүгийн бүртгэлийн эх байдаг. Хэрэв та жижиг бизнестэй бол бизнесийн зарлага болон хувийн зарлагаа хатуу зааглаж байх шаардлагатай.

Бүртгэл бол зөв шийдвэр гаргах үндэс суурь

Таны санхүүгийн тооцоо бүртгэл томорч илүү ярвигтай болохын хэрээр танаас аль болох түргэн хялбархан байсан ч хамаагүй бүртгэл хөтлөлтийн компьютерийн системийг нэвтрүүлж, түүн дээр ажиллах итгэлтэй хүнээ сургаж авахыг танаас шаардах болно. Данс бүртгэл нь нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын нарийвчилсан тооцоог харуулдаг.



Зээлдэгчээ үнэл

Бизнес эрхлэгч бүр хөдөлмөрийнхөө үр жимсийг хураах хүсэлд автдаг. Хэрэв таны үйлчлүүлэгчид төлөх ёстой төлбөр тооцоогоо цаг хугацаанд нь төлж барагдуулахгүй бол танай компани санхүүгийн хүндрэлд орох магадлалтай. Эрсдэлээс сэргийлэхийн тулд шинэ худалдан авагчдаас мөнгөө урьдчилан төлөхийг шаардах нь хамгийн зөв арга байдаг.

Бүх хөрөнгөө бүртгэ

Танай үйлдвэрийн газар, барилга байгууламж байнгын арчилгаа сайтай, цэвэр цэмцгэр байхад анхаар. Энэ бүхэн ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой. Хангамжийн зүйлсийг нарийн бүртгэж байх нь болзошгүй хулгай, алдагдал дутагдлаас сэргийлэх ач холбогдолтой.

Хэт хурдан өсөлтөд бүү шуна

Та бизнесийнхээ эргэлтийг нэг дор хоёр дахин өсгөж чадахгүй ч дараа жил гэхэд эргэлтээ арван хувиар өсгөх зорилт тавьж яагаад болохгүй гэж.

ХЭТЭРХИЙ ТҮРГЭН ТОМРОХ ГЭЖ БҮҮ ЯАР!



Зайлшгүй даатгалыг хий

Та өөрийгөө болон ажилтнуудаа болзошгүй галын аюул, хулгай, осол гэмтлээс хамгаалах даатгалд даатгуул. Ингэх нь танай байгууллагын ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйд сайнаар нөлөөлөхөөс гадна бүхэлдээ таны бизнесийн үйл ажиллагаанд ашиг тусаа өгнө. Энэ чиглэлд байгууллагын нэр хүнд өсөх боломжтой бөгөөд шинэ үйлчлүүлэгчид, шинэ ажилтнуудын анхаарлыг татах сайн талтай.



Итгэлтэй, чадварлаг ажилтнуудыг олж ав

Итгэлтэйн хажуугаар маш сайн бэлтгэгдсэн ажилтнууд танд хэрэгтэй. Бизнес өргөжихийн хэрээр үүрэг хариуцлага тээж, та зарим эрх үүргээ бусдад шилжүүлэх шаардлага тулгарна. Тэр үед салбар хэсэг бүрээрээ тарж бутран дур дураараа авирлахаас сэргийл, одооноос бэлтгэ.

Сайн данс бүртгэлд нууц зүйл гэж үгүй

Данс бүртгэл гэдэг бол өөрийн гэсэн үг хэллэг бүхий тусдаа ухагдахуун юм. Тиймээс та данс бүртгэлийг сайн ойлгож байхын тулд бүртгэлийн мэргэжлийн хэлийг нь мэддэг байх шаардлагатай. Мөн та нярав, нягтландаа бүх санхүүгийн эрх мэдлийг даатган орхих нь бизнесийн үйл ажиллагаандаа шийдвэр гаргахад хүндрэл үүсгэхээс гадна хяналт хийх боломжийг бууруулна. Данс бүртгэл гэдэг нь тийм ч айтхар ойлгоход хэцүү, үр дүнг нь тооцоход бэрх нарийн шинжлэх ухаан биш. Энэ бол одоо болж буй бүх зүйлийн үнэн бодит тусгал, ирээдүйг тооцож, таны гаргах шийдвэрүүдийн үндэс суурь юм.



4.ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ

ЗЭЭЛ АВАХДАА БАНКАА ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Танд тодорхой хэмжээний мөнгө хэрэгтэй болоод та зээл авах гэж байгаа. Мэдээж зээлээр авсан мөнгөө юунд зарцуулахаа мэдэж байгаа болохоор өнөөгийн банкнуудын яг түүнд тохирсон үйлчилгээг сонгох нь ойлгомжтой.

Харин аль банкыг сонгох вэ гэж эргэлзэж байна уу?

Үүний тулд юу анхаарах ёстой вэ?

- Таны авахаар товлосон зээл аль банкуудад хамгийн бага хүүтэй байна вэ?
- Төлөх нөхцөл нь аль банканд хамгийн уян хатан, таны сэтгэлд нийцэж байна вэ?
- Танд мөнгөний боломж гараад зээл, зээлийн хүүгээ байгуулсан гэрээнээсээ өмнө төлөхөд ямар давуу тал, хөнгөлөлт аль банканд илүү байна?
- Юмыг яаж мэдэх вэ, та зээл, зээлийн хүүгээ төлөх хугацааг хэтрүүлчихвэл аль банк илүү хатуурхаж, алданги торгууль илүү бодох бол?

зэргийг маш сайн судалж байж үйлчлүүлэх банкаа сонгох нь зүйтэй.

БАНКНААС ЗЭЭЛ ХҮСЭХЭД ЗАВАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ 5 ЗАРЧИМ

Орчин үеийн нийгэмд зээл бол санхүүгийн хамгийн том хөшүүрэг болоод байна. Зээлгүйгээр бүтэх ажил, урагшлах бизнес гэж ховор. 100 төгрөг зээлээд нэг саяыг хүримтлүүлж чадвал тэр жинхэнэ бизнесмэн. Гэхдээ тэр өндөрлөгт хүрэхийн тулд зээлийг хэнээс, хаанаас авах вэ гэдэг бас их чухал юм. Өнөө цагт бизнес эрхэлж буй хүмүүсийн санхүүгийн гол багана нь банк болоод байна.

Тиймээс банкны шалгуурт нийцсэн хүн л зээл авах боломжтой гэж ойлгож болох юм. Гэхдээ тэр шалгуур нь чухам юу байх, түүнийг нь хэрхэн хангалттай хэмжээгээр бүрдүүлж чадах эсэхээ тухайн хүн яаж мэдэх вэ?

Банк тухайн хүнд зээл өгөх эсэхээ шийдэхдээ тодорхой зарчмуудыг баримталдаг бөгөөд та дараах таван зарчмыг биелүүлчихсэн байхад асуудалгүй зээл авах боломжтой болно. Үүнд:

1. Зээлийн хэрэгцээгээ тодруулсан байх
2. Банкны суурь шаардлагыг хангасан байх
3. Авсан зээлээ төлж чадахуйц орлогоо нотлох
4. Төлж чадна гэдгээ батлах
5. Барьцаа хөрөнгөтэй байх

Банк танаас юу шаардах вэ?

Та зээл авахын тулд тухайн банкны суурь шаардлагуудыг хангасан байх ёстой. Банкууд вэб сайт болон брошураараа дамжуулан суурь шаардлагуудаа дэлгэн тавьдаг. Тиймээс тэдгээрээс эхлээд мэдээллээ авна гэсэн үг. Ер нь дийлэнхдээ аль ч банк таниас шаардах нийтлэг зүйл нь:

- Тодорхойлох боломжтой орлогоороо банкнаас тавьж буй шалгуурыг хангах, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрөө төлөх боломжтой байх,
- Зээл хүсэгч болон хамтран үүрэг гүйцэтгэгч нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байх,
- Тухайн байгууллагад ажиллаж байх, цаашид тогтвор суурьшилтай ажиллах, сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тухайн байгууллагад ажилласан байх,
- Банк шаардсан тохиолдолд хөрөнгө барьцаалах, даатгуулах боломжтой байх,
- Банк шаардсан тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгчтэй байх,

Бүрдүүлэх материал:

- Сүүлийн 6 сарын хугацааны дотор авахуулсан цээж зураг
- Цахим үнэмлэх эх хувиар, эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар / зээлдэгч болон хамтран үүрэг гүйцэтгэгч тус бүрийн/
- Барьцаа хөрөнгийн бичиг баримтууд
- Бусад банк болон ББСБ-аас авсан төлөгдөөгүй зээлийн өрийн үлдэгдэлтэй зээлийн гэрээ, дансны хуулга/төлбөр төлсөн баримт зэргийг эртнээс бэлтгэсэн байхад гэмгүй шүү.

Банкны дээрх шаардлагуудыг та хангаж байна уу. Үүнийг дахин нэг нягтлаад үзээрэй. Материал дутуу бол дахиад л бүрдүүлэх шаардлага гарч, цаг алдахын нэмэр шүү дээ.



5. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БУЙ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСЛҮҮД

ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:
Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг

Зээлийн зорилго

- Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах
- Бага хүүтэй, урт хугацааны санхүүжилт олгох замаар жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих
- Байгаль орчныг хамгаалах

Зээлийн зориулалт:

- Эргэлтийн хөрөнгө
- Тоног төхөөрөмж худалдан авах
- Үйлдвэрийн барилга байгууламж барих, өргөтгөх

Санхүүжилтийн хэмжээ:

10.000-400.000 доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг

Зээлийн хүү жилээр: Төгрөг 8%
Доллар 5,3% бөгөөд 6 сар тутамд хувьсах хүүтэй

Зээлийн хугацаа:

3-10 жил /1-3 хүртэл жил үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлнө/



ТӨСЛИЙН ЗЭЭЛ

Зээл хүсэгчид тавигдах нэмэлт шаардлага:

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага
- Хувийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж байгууллага байх
- Санхүүжүүлэх төслөө бичсэн байх
- Төслийн нийт санхүүжилтийн 20 хувийг өөрөө санхүүжүүлэх чадвартай байх
- Зээлийн эргэн төлөлтийн харьцаа 1.3 ба түүнээс их байх
- Хөрөнгө оруулалтын өгөөж 13%-аас доошгүй байх
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэлгүй, муу зээлийн түүхгүй байх
- Үндсэн ажилчдын тоо 299 ба түүнээс бага байх
- Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх ба шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийлгэх

6. ЗЭЭЛИЙН БОЛОВСРОЛ

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БОДОХ ЭНГИЙН АРГАЧЛАЛ:



Хүү бодох аргачлалыг энгийнээр тайлбарлахын тулд зээлийн дүн, хүүгийн төлбөр, үндсэн дүн, зарласан хүү, ашигласан хоног зэргийг ойлгох зайлшгүй шаардлага гарч ирнэ, тиймээс эдгээрийг нэн тэргүүнд тайлбарлая.

- **Зээлийн дүн** гэдэг маань таны банкнаас анх авсан зээлийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэхийг хэлнэ.
- **Үндсэн дүн** гэдэг нь та тухайн зээл авч буй банктайгаа тохиролцон сар, улирал, жилээр тухайн зээлээсээ хэсэгчлэн төлөх зээлийн дүнг хэлнэ.
- **Зарласан хүү** гэдэг нь банкнаас олгох зээлд тооцохоор тохиролцож нийтэд зарласан жилд төлөх зээлийн хувь хэмжээг хэлнэ.
- **Ашигласан хоног** гэдэг нь банктай хийсэн гэрээнд төлбөр төлөхөөр тохиролцсон хуваарьт өдрүүдийн хоорондох хоногийг хэлнэ.
- **Хүүгийн төлбөр** гэдэг нь зээл авсан хүн банкнаас авсан зээлийн хэмжээ, гэрээнд тусгасан хүүгийн хувь хэмжээ, зээлийг ашигласан хугацаанаасаа хамааруулан банкинд төлж буй төлбөрийг хэлнэ.

Одоо зээлийн хүүгийн төлбөрөө тооцох аргачлалыг тодруулж үзье.

Зээлийн хүүгийн төлбөр = Зээлийн дүнг * Зарласан хүүгийн хэмжээ / 365 * ашигласан хоног гэсэн томъёогоор зээлийн хүүгийн төлбөрийг тооцох нь байна.

Эхний жишээ: Зээлийн хэмжээ-1,000,000 төг-ийг, 2014/4/17-ны өдөр 6 сарын хугацаатай авч, зарласан зээлийн хүү- 20.0%. Эхний төлбөрийн хугацаа 2014/5/17 гэж гэрээнд заасан бол хэдэн төгрөгийн зээлийн хүү төлөх вэ?

Эхний алхам.

Зээлийн хэмжээ	1,000,000 төг
Зээлийн зарласан хүү	20,0%
Зээл авсан өдөр	2016/4/17
Зээл төлөх өдөр	2016/5/17 гэсэн мэдээллээ тэмдэглэнэ.

Дээрх мэдээллийг зээлийн хүүгийн төлбөр олох томъёондоо оруулбал:

Зээлийн хүүгийн төлбөр = $1.000.000 * 20\% / 365 * \text{ашигласан хоног}$ гээд оруулах бөгөөд тооцож гаргахад **ашигласан хоног** нь тодорхойгүй учраас тооцох боломжгүй ээ.

Дараагийн алхам.

Тиймээс одоо ашигласан хоногоо олох хэрэгтэй!

Бид 2016/4/17 өдөр зээл авсан, харин зээлээ төлөх эхний өдөр маань 2016/5/17 байгаа энэ хооронд бид: 4-р сар 30 хоногтойгоос ашиглаагүй 17 хоногоо хасвал 13 хоног, 5-р сарын 17 хүртэл 17 хоног ашигласан учир нийт 13+17 буюу 30 хоног 1.0 сая төг-ийг ашигласан гэсэн үг. Энэ загвараар зээлийн хүүгийн төлбөрөө тооцвол:

Зээлийн хүүгийн төлбөр = $1,000,000 \text{ төг} * 20\% / 365 \text{ хоног} * 30 \text{ хоног} = 16,438.36 \text{ төг}$ болж байна.

Эл жишээлбэрээс харахад бид эхний сард зөвхөн хүүгийн төлбөртөө 16,438.36 төг төлөх ёстой болох нь ээ.

НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮ БУЮУ "АЛДАНГИ"-Г ЯАЖ ТООЦДОГ ВЭ?

Зээлээ хугацаанд нь төлж чадахгүй байгаа хүний хувьд "Зээлийн хугацаагаа сунгаж болох болов уу" эсвэл "ямар хэмжээний алданги гарч байгаа бол" гэсэн бодол толгойд нь эргэлдэж байдаг.

"Банк, эрх бүхийн хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухайхууль"-нд үүнийг нэмэгдүүлсэн хүү гэж нэрлэдэг бөгөөд үндсэн хүүний хорин хувиас хэтрүүлэхгүй тогтоож байхаар заажээ.

Тухайлбал таны авсан зээл сарын 2,5% хүүтэй бол сард тооцож болох **нэмэгдүүлсэн хүү** (бидний ярьж заншсанаар алданги) сарын 0,5% байна гэсэн үг юм. Сарыг 30 хоногтой гээд үзвэл энэ нь өдрийн 0,017% хүү нэмж бодно гэсэн үг. Тэгээд зээлийн хүү боддогтой яг адилхан хэдэн хоног зээлээ төлөхгүй хугацааг нь хэтрүүлсэн тэр хоногоор тооцдог.

Харин ямар дүнгээс нэмэгдүүлсэн хүүг боддог вэ?

Үндсэн хүүг бодохдоо нийт зээлийн үлдэгдэл дүнгээс тооцдог бол **нэмэгдүүлсэн хүүг тооцохдоо төлөгдөх хугацаа нь болсон ч төлөөгүй байгаа зээлийн дүнгээс тооцдог**. Жишээлбэл 5 сая төгрөг авсан хүн энэ сард зээлнээсээ 300,000 төгрөг төлөх ёстой байсан ч түүнийхээ 100,000 төгрөгийг төлөөд үлдсэн нь төлөөгүй бол нэмэгдүүлсэн хүүг тооцохдоо энэ сард төлөх ёстой байсан боловч төлөөгүй байгаа 200,000 төгрөгөөс тооцно. Зарим хүмүүс нийт зээлийнхээ үлдэгдлээс бодох ёстой гэсэн ташаа ойлголттой байдаг. Тухайлбал төлөх ёстой хугацаанаасаа 6 хоног өнгөрчихсэн бөгөөд нэмэгдүүлсэн хүү нь сарын 0,5% гэж үзвэл тухайн хүний энэ 6 хоногт төлөх ёстой нэмэгдүүлсэн хүү нь доорх томъёогоор бодогдоно.

Нэмэгдүүлсэн хүү = $(200,000 * 0.5\% / 30) * 6$

Тооцоод үзэхээр 200 төгрөгний нэмэгдүүлсэн хүү төлөх ёстой болж байна.

7. САЛБАРУУДАД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС

БАЯН-ӨЛГИЙ САЛБАР

Баян-Өлгий аймагт 10 сарын 1-2-нд аймагт томоохон тооцогддог Бүргэдийн Баяр 2016 фестиваль зохион байгуулагдаж, гадаад дотоодын нийт 1000 гаруй зочид, төлөөлөгч, жуулчид оролцлоо. Тус үйл ажиллагаанд REACH Баян-Өлгий салбар аймгийн ЗДТГ-тай хамтран гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 40 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулсан “Гар урлалын үзэсгэлэн худалдаа”-г амжилттай зохион байгуулж, фестивалд хүрэлцэн ирсэн олон улсын зочид, төлөөлөгч, жуулчдад аймгийн өв соёл, уламжлал, авьяас ур чадвар шингэсэн бүтээлүүдийг сонирхуулан танилцууллаа.



ДУНДГОВЬ САЛБАР

Дундговь салбарт 2016.10.12-нд ЖДБ-дэд зориулсан “Санхүүгийн шинжилгээ ба хэрэглээ” сэдэвт ээлжит сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар ЖДБ-дэд бизнесийн үйл ажиллагааны тодорхой мөчлөг хугацааны эцэст тасалбар болон гарж байгаа санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүдийг шинжилж, бизнесийн шийдвэр гаргалт болон төлөвлөлтөнд ашиглаж сурах үр дүнтэй сургалт боллоо.



ДОРНОД САЛБАР

Дорнод салбарт 10-р сарын 18-нд “Бизнес төсөл боловсруулах ур чадвар олгох сургалт” боллоо. Сургалтад хамрагдсан ЖДБ эрхлэгчид бизнес төслийн тухай ойлголт, хөрөнгө оруулагч санхүүжүүлэгч нарт хандсан төслөө үнэн бодитой шаардлагад нийцүүлэн боловсруулж, санхүүжилт авах боломжийн талар мэдээлэлтэй боллоо. Дорнод салбарын ээлжит сургалт 11 сарын 17-нд болох тул салбарын 7036-3440 утасаар холбогдон бүртгүүлнэ үү.



СЭЛЭНГЭ САЛБАР

Сэлэнгэ салбарт 2016.10.25-ны өдөр “Бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлал” сургалт зохион байгуулагдаж, Сэлэнгэ аймгийн Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид хамрагдлаа. Сургалтаар бизнесийн удирдлага, төлөвлөлтийн үндсэн ойлголтуудын талаар мэдлэг олгохоос гадна төслийн тухай ойлголт болон төсөл бичих ур чадвар олгов. Сэлэнгэ салбарын ээлжит сургалт 11 сарын 15-нд болох тул салбарын 7058-2030 утасаар холбогдон бүртгүүлнэ үү.




8. БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

**ХЯМРАЛ ГЭДЭГ ҮГ ХҮЁР ҮГЭЭС БҮРДДЭГ:
"АЮУЛ" БОЛОН "БОЛОМЖ"**

Хямралын менежмент.

Хүмүүн төрөлхтөн түүхэндээ байгалийн гамшгаас эхлээд өөрсдийн хийж бүтээсэн зүйлүүдээс болж олон хямралтай тулгарч ирсэн билээ. Бизнес ч гэсэн үүнтэй адил дотоод болон гадаад үйл явдал, хүчин зүйлээс шалтгаалан аюул нүүрлэнэ. Жишээ нь байгалийн тааварлашгүй хүндрэлүүдийн үед удирдлагаас шийдвэр хурдан гаргаж, хариу үйлдэл хийхийг шаарддаг.

Даяарчлал бизнесийн ертөнцөд ихээр явагдаж, нэг улс орны өөрчлөлт дэлхий дахинд, бусад улсуудын бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх болов. Үүнтэй зэрэгцэн 24/7 горимын дижитал харилцаа мэдээллийг хурдан шуурхай, дэлхийн хаанаас ч дамжуулах болсон учраас хямралын үр нөлөө ч дижиталын өмнөх эрин үеэс илүү хурдан, хүчтэй түгэх болсон билээ.



Төлөвлөлт ба шийдвэр.

Хямралын үр нөлөөтэй менежмент хямралыг даван туулах мэргэжлийн аргачлалаар боловсруулсан нарийн төлөвлөгөөн дээр суурилдаг. Энэ нь хямралын "хэн, юу, хэзээ, хаана, яаж" гэсэн асуултуудын хариултуудыг хурдан тодорхойлоход тусална. Хямрал ямар ч жижиг хэмжээтэй байсан пүүсийн олон нийтэд чиглэсэн хариу үйлдэл хурдан байхын тулд үргэлж мэдээлэгдэж, анзаарагдаж байх шаардлагатай. Олон нийтийн ойлголт хэрэглэгч, худалдан авагчдын итгэл үнэмшилд нөлөөлдөг.

Түргэн шуурхай, үр нөлөөтэй шийдвэр төгс манлайлал хямралын үеэр чухал ач холбогдолтой. Пүүс бүр хямралыг сайн давж, хохирлыг хамгийн бага хэмжээнд барьж чадвал нэр хүндэд нь маш сайн нөлөө үзүүлж болохыг ойлгодог. АНУ-ын ерөнхийлөгч Жон Кеннеди "Хятад хэлэнд "Хямрал" гэдэг үг хоёр ханзаас бүрддэг: Аюул болон Боломж" хэмээн хэлжээ.

"Хямралын үр нөлөөтэй менежмент болбоос хэзээ ч дуусашгүй үйл явц буюу дан ганц эхлэл болон төгсгөлд хийгдэх үйл ажиллагаа биш".

*Йан Митрофф, Пол Шривастав,
Фурдаус Удвайда*

9. REACH ТӨСЛИЙН 12 САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- 2016.12.06-08 Улаанбаатар хот "Бизнес Төсөл Боловсруулах Аргачлал", "Санхүүгийн Тайланг Уншиж ойлгох нь", "Санхүүгийн Тайлангийн Шинжилгээ ба Хэрэглээ", "Зээлийн Боловсрол" сэдвээр сургалт
- 2016.12.08-12 Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймгуудад Нягтлан Бодох Бүртгэл сэдвээр сургалт
- 2016.12.15 Багануур дүүрэгт ЖДҮ эрхлэгч нар ажил хэрэгч уулзалт
- 2016.12.21-23 Улаанбаатар хот "Бизнес Төсөл Боловсруулах Аргачлал", "Санхүүгийн Тайланг Уншиж ойлгох нь", "Санхүүгийн Тайлангийн Шинжилгээ ба Хэрэглээ", "Зээлийн Боловсрол" сэдвээр сургалт

Та дээрх сургалт, уулзалтанд бүртгүүлэх бол:

- **Улаанбаатар Оффис:**
№: 703, МАКС Тауэр, Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Утас: 7722-2210, И-мэйл: reach@dsmongolia.org
- **Баян-Өлгий Салбар**
№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг. Утас 7042-2080
- **Дундговь Салбар**
№ 205 тоот Мандал Шилтгээн ХХК-ийн байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан Сум, Дундговь аймаг. Утас 7059-2209
- **Дорнод Салбар**
№11 тоот, Ольхон Худалдааны Төв, 9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг. Утас 7058-2030
- **Сэлэнгэ Салбар**
№1 тоот, Алтан Булаг Төв, Сүхбаатар сум, 2-р Сэлэнгэ аймаг. Утас 7036-3440

"Энэхүү сонинг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь сонинтой холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно."